

"ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП" ХК-ИЙН САНХҮҮГИЙН ЖИЛИЙН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

| | | | | | | | | | |
|---|---|-----------------------------|--------------------------|----------------|--------------------------|---------------------------|--------------------------|--------------------------|--------------------------|
| Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1 / | | | | | | | | | |
| Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй. | | | | | | | | | |
| Тайлагнах хугацаа /Жишээ нь: | 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/ | | | | | | | | |
| Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар | "ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП" ХК, 9007001003, MSE:TNGR, 89074970, 95432111 | | | | | | | | |
| Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр | Монголын хөрөнгийн бирж | | | | | | | | |
| Бизнесийн үйл ажиллагааны салбар | Хэвлэл мэдээлэл, контент үйлдвэрлэл | | | | | | | | |
| Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо | "БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК, СЗХ-ны 2012 оны 08-р сарын 08-ны өдрийн 259-р тогтоол | | | | | | | | |
| Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг | 6,000,000 | | | | | | | | |
| Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэй, хянасан албан тушаалтны нэр | Бэлтгэсэн: Үйл ажиллагаа хариуцсан захирал Б.Батзаяа ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Удвал Хянасан: Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ | | | | | | | | |
| 1. | Тайланг жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/ <table border="1" data-bbox="223 1523 1508 1780"> <tr> <td>Санхүүгийн байдлын үзүүлэлт</td> <td><u>Тайланг хавсаргав</u></td> </tr> <tr> <td>Орлогын тайлан</td> <td><u>Тайланг хавсаргав</u></td> </tr> <tr> <td>Өмчийн өөрчлөлтийн тайлан</td> <td><u>Тайланг хавсаргав</u></td> </tr> <tr> <td>Мөнгөн гүйлгээний тайлан</td> <td><u>Тайланг хавсаргав</u></td> </tr> </table> | Санхүүгийн байдлын үзүүлэлт | <u>Тайланг хавсаргав</u> | Орлогын тайлан | <u>Тайланг хавсаргав</u> | Өмчийн өөрчлөлтийн тайлан | <u>Тайланг хавсаргав</u> | Мөнгөн гүйлгээний тайлан | <u>Тайланг хавсаргав</u> |
| Санхүүгийн байдлын үзүүлэлт | <u>Тайланг хавсаргав</u> | | | | | | | | |
| Орлогын тайлан | <u>Тайланг хавсаргав</u> | | | | | | | | |
| Өмчийн өөрчлөлтийн тайлан | <u>Тайланг хавсаргав</u> | | | | | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайлан | <u>Тайланг хавсаргав</u> | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|--|---|--|----------------------------|------|------------------------------|------|-------------------------------------|--|-----------------------|-------|-------------------------|------|----------------------------|--|-----------------------------|-----|------------------------|-----|--------------------------------|--|--|------|
| 1.1. | Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | <u>Аудитын дүгнэлтийг хавсаргав.</u> | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 1.2. | Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/ | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | <u>Аудитын тодорхойлох захидлыг хавсаргав.</u> | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2. | Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2.1. | Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/ | <table border="1"> <tr> <td colspan="2">Санхүүгийн үзүүлэлтүүд</td> </tr> <tr> <td colspan="2">Ашигт ажиллагаа</td> </tr> </table> | Санхүүгийн үзүүлэлтүүд | | Ашигт ажиллагаа | | | | | | | | | | | | | | | | | |
| Санхүүгийн үзүүлэлтүүд | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Ашигт ажиллагаа | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2.2. | Хөрвөр чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт | <table border="1"> <tr> <td>Нийт хөрөнгийн өгөөж (ROA)</td> <td>2.8%</td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)</td> <td>3.8%</td> </tr> <tr> <td colspan="2">Өөрчлөлтийн хувь /оны эхээс/</td> </tr> <tr> <td>Нийт активын өөрчлөлт</td> <td>4297х</td> </tr> <tr> <td>Зээлийн багцын өөрчлөлт</td> <td>100%</td> </tr> <tr> <td colspan="2">Хөрөнгөд эзлэх хувь</td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө</td> <td>82%</td> </tr> <tr> <td>Өр төлбөр/Нийт хөрөнгө</td> <td>17%</td> </tr> <tr> <td colspan="2">Хөрвөх чадварын харьцаа</td> </tr> <tr> <td>Хөрвөх чадварын хөрөнгө /Татан төвлөрүүлсэн хөрөнгө/</td> <td>4.26</td> </tr> </table> | Нийт хөрөнгийн өгөөж (ROA) | 2.8% | Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) | 3.8% | Өөрчлөлтийн хувь /оны эхээс/ | | Нийт активын өөрчлөлт | 4297х | Зээлийн багцын өөрчлөлт | 100% | Хөрөнгөд эзлэх хувь | | Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө | 82% | Өр төлбөр/Нийт хөрөнгө | 17% | Хөрвөх чадварын харьцаа | | Хөрвөх чадварын хөрөнгө /Татан төвлөрүүлсэн хөрөнгө/ | 4.26 |
| Нийт хөрөнгийн өгөөж (ROA) | 2.8% | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) | 3.8% | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Өөрчлөлтийн хувь /оны эхээс/ | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Нийт активын өөрчлөлт | 4297х | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Зээлийн багцын өөрчлөлт | 100% | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Хөрөнгөд эзлэх хувь | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө | 82% | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Өр төлбөр/Нийт хөрөнгө | 17% | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Хөрвөх чадварын харьцаа | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Хөрвөх чадварын хөрөнгө /Татан төвлөрүүлсэн хөрөнгө/ | 4.26 | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2.3. | Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл | Ковид-19 цар цахлын нөлөө, хил гаалийн удаашрал мөн долларын ханшийн өсөлт эдгээрээс үүдсэн тоног төхөөрөмж, барилгын материалын түүхий эдийн үнийн өсөлт зэрэг нь ТэнГэрЛиг Медиа Группийн шинээр хэрэгжүүлж буй томоохон төслүүд болох ТэнГэрТВ болон ОриСтудиос нарын бүтээн байгуулалтын ажилд нэлээдгүй нөлөөлсөн. 2021 оны 2 хагаст албан ёсоор үйл ажиллагаагаа эхэлсэн тул салбарт эзлэх хувь хэмжээ дээр дурдсан төслүүдийн үйл ажиллагаа эхэлсний дараагаар буюу 2022 оны жилийн эцэст тодорхой болох төлөвтэй байна. | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2.4. | Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/ | Санхүү байдлын тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй. | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2.5. | Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл; | 2021 онд “Ард Актив” ХЗХ-с 1,430,000,000 төгрөгийн зээл авсан бөгөөд компанийн эзэмшлийн 30 сая ширхэг АрдКойныг зээлийн барьцаанд тавьсан . 56.8 сая төгрөгийн зээлийн хүүгийн өрийг төлсөн. | | | | | | | | | | | | | | | | | | | | |

| | |
|----|---|
| 3. | <p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p> |
| | <p>2021 оны 09 дүгээр сарын 16-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хийх зөвшөөрөл олгосон. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Компанийн нэмж гаргасан хувьцаанаас 1,803,550 ширхэг хувьцааг "Гэр Интерьер Дизайн" ХХК-д шилжүүлэн, хувьцаа худалдах худалдан авах гэрээг байгуулсан. Хувьцааны хариу төлбөрт "Про Медиа Нетворк" ХХК-ийн хувьцааны 80% буюу 3,929,935,450 төгрөгийн үнийн дүн бүхий хувьцааг авсан. Ийнхүү "Про Медиа Нетворк" ХХК нь "Тэнгэрлиг Медиа Групп" ХК-ийн охин компани болсон. 2. Компанийн нэмж гаргасан хувьцаанаас 1,376,779 ширхэг хувьцааг "Гэр Интерьер Дизайн" ХХК-д шилжүүлэн, хувьцаа худалдах худалдан авах гэрээг байгуулсан. Хувьцааны хариу төлбөрт "Анрид" ХХК-ийн хувьцааны 66% буюу 3,000,001,441 төгрөгийн үнийн дүн бүхий хувьцааг авсан. Ийнхүү "Анрид" ХХК нь "Тэнгэрлиг Медиа Групп" ХК-ийн охин компани болсон. 3. Компанийн нэмж гаргасан хувьцаанаас 692,175 ширхэг хувьцааг МУ-ын иргэн Л.Чинбат-д шилжүүлэн, хувьцаа худалдах худалдан авах гэрээг байгуулсан. Хувьцааны хариу төлбөрт "Монгол Телевиз" ХХК-ийн хувьцааны 20% буюу 1,508,249,325 төгрөгийн үнийн дүн бүхий хувьцааг авсан. Ийнхүү "Монгол Телевиз" ХХК нь "Тэнгэрлиг Медиа Групп" ХК-ийн хараат компани болсон. 4. Компанийн нэмж гаргасан хувьцаанаас 692,175 ширхэг хувьцааг МУ-ын иргэн Г.Бат-Эрдэнэ-д шилжүүлэн, хувьцаа худалдах худалдан авах гэрээг байгуулсан. Хувьцааны хариу төлбөрт "Ори Студиос" ХХК-ийн хувьцааны 20% буюу 1,508,249,325 төгрөгийн үнийн дүн бүхий хувьцааг авсан. Ийнхүү "Ори Студиос" ХХК нь "Тэнгэрлиг Медиа Групп" ХК-ийн хараат компани болсон. |
| 4. | <p>Цалин урамшууллын мэдээлэл</p> |
| | <p>2021 онд ТУЗ-ийн гишүүдэд цалин урамшуулал олгоогүй. Гүйцэтгэх удирдлагад 56.5 сая төгрөгийн цалин олгосон.</p> |
| 5. | <p>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</p> |
| | <p>2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 21/02 тоот тогтоолоор дараах гишүүдийг Төлөөлөн удирдах зөвлөлд томилсон. Үүнд:</p> <p>Ердийн гишүүд: Г.Уянга, Ө.Ашхүү, Ц.Бархас, Ч.Хандаа, Г.Оргил Хараат бус гишүүд: Х.Эрдэнэбаяр, Д.Ганзориг, Б.Батзаяа, А.Ундрал</p> <p>2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 21/06 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргаар Г.Уянгыг томилсон.</p> <p>2021 оны 5 дугаар сарын 21-ний ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 21/08 тоот тогтоолоор Гүйцэтгэх захирал Ч.Хандааг чөлөөлж, 21/09 тоот тогтоолоор Г.Бат-Эрдэнийг Гүйцэтгэх захирлаар томилсон.</p> <p>ТУЗ нь 2021 онд нийт 10 удаа хуралдаж, үүнээс цахимаар 1 удаа, биеллэн оролцсон 5 удаа, эчнээ хэлбэрээр 4 удаа хуралдсан. Мөн компани нь Аудитын хороо; Хөрөнгө оруулалт, санхүү эрсдэлийн хороо; Засаглал нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороотой.</p> |
| 6. | <p>Зах зээлийн эрсдлийн мэдээлэл</p> |
| | <p>Байхгүй.</p> |

| | |
|-----|---|
| 7. | Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо |
| | <p>Компанийн эцсийн өмчлөгч: 37.08%-ийн хяналтын багц эзэмшигч “Гэр Интерьер Дизайн” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Уянга</p> <p>2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар компанийн нийт 6,000,000 хувьцааг 556 хувь хүн, аж ахуй нэгж эзэмшиж байна. 5 хувь буюу түүнээс дээш хувьцаа эзэмшигчид:</p> <ol style="list-style-type: none"> 1. Гэр Интерьер Дизайн ХХК – 37.08% - 2,225,097 2. Ард Санхүүгийн Нэгдэл ХК – 23.22% - 1,393,099 3. Г.Бат-Эрдэнэ – 11.54% - 692,292 4. Л.Чинбат – 11.54% - 692,175 5. Н.Мөнхнасан – 10% - 600,000 |
| 8. | Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл |
| | <p>2021 онд нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй. Хаалттай хүрээнд 5,941,457 хувьцаа нэмж гаргах зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн №344 тоот тогтоолоор олгосон.</p> |
| 9. | Ногдол ашгийн мэдээлэл |
| | <p>Тэнгэрлиг Медиа Групп ХК-ийн санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааг цаашид хэвийн явуулахтай холбоотойгоор 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн төлөөлөн удирдах зөвлөлийн 22/02 тоот тогтоолоор ногдол ашиг хуваарилахгүй шийдвэр гаргасан болно.</p> |
| 10. | Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл |
| | <p>Монголын Ротаракт клубуудын 2012 оноос хойш 9 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж буй “Бяцхан баатрууд” төсөлд мөнгөн хандив өгсөн ба тус төслийн зорилго нь шинэ жилийн баярыг тохиолдуулан Улаанбаатар хотын эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа болон алслагдсан дүүрэгт амьдардаг хүүхэд багачуудад инээд хөөр, урам зориг бэлэглэн мартагдашгүй дурсамжийг бүтээлцэхэд оршдог. Хүүхдэд ээлтэй эрүүл мэнд, амттан болон хичээлийн хэрэгслийн багцыг сарын хугацаанд цуглуулан хүүхдүүдэд бэлэглэдэг.</p> |

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг огноо:

Овог, нэр:

Албан тушаал “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн
Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:
(Тамга/тэмдэг)



Овог, нэр:

Албан тушаал: “.....” ..К аудитын компанийн
Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:.....
(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: *Анхбаяр Чувал*

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: *А.Ч*



Г САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД 7

БЭЙКЕР ТИЛИ ДАЛАЙВАН АУДИТ ХХК

Аудит, баталгаажуулалт, хөрөнгийн болон
бизнесийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ
Монгол Улс, Улаанбаатар хот-16066, Баянголдүүрэг,
Амарсанаагийн гудамж-5, Өөрийн байр
Утас: 70005401, 70005402, Факс: +976-70005403
Э.Шуудан: info@btdalaivanaudit.mn
Веб хуудас: www.btdalaivanaudit.mn

2022.03.29 № 62
Тамга № -Т

Г Аудитын тодорхойлох захидал 7

Бэйкер Тилли Далайван Аудит ХХК нь Тэнгэрлиг Медиа Групп ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж дүгнэлтээ гаргасан.

Бидний 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөр огноолсон хараат бус аудитын тайланд тусгасанчлан компанийн санхүүгийн тайлангууд нь компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлого, зардлын гүйцэтгэл, үр дүн болон мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг бүх материаллаг талаараа СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн болно.

Бид аудит хийхдээ Аудитын Олон Улсын Стандарт (АОУС) болон ёс зүйн шаардлагуудыг мөрдөн ажилласан ба манай аудитын компани болон аудитыг гүйцэтгэсэн аудитын багийн гишүүд нь үйлчлүүлэгчтэй сонирхлын зөрчилгүй, үйлчлүүлэгчээс хараат бус байдлаар ажилласан болно.

Санхүүгийн мэдээлэл болон энэхүү албан тодорхойлолт нь компанийн санхүүгийн тайлангуудад гаргасан аудиторын дүгнэлтийг орлохгүй бөгөөд СТОУС болон Монгол улсын хууль, дүрэм, журмаар шаардсан нэмэлт бүх тодруулга, мэдээллийг агуулаагүй болно.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Ц.ЖИГДЭН



БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ

Аудит, баталгаажуулалт, хөрөнгийн болон
бизнесийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
Утас: 70005401, 70005402
Факс: +976-70005403
Э.Шуудан: info@btdalaivanaudit.mn
Вэб хуудас: www.btdalaivanaudit.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Санал дүгнэлт

Бид 2021 оны 12 дугаар сарын 31-ээрх тусдаа санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Тэнгэрлиг медиа групп” ХК-ийн тусдаа санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Тэнгэрлиг медиа групп” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх тусдаа санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, тусдаа өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, “Тусдаа санхүүгийн тайлан” (НББОУС 27)-ын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн тусдаа санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид тусдаа санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

Асуудлыг онцлох нь

Тусдаа санхүүгийн тайлангийн тодруулга 6.13, өөрийн хөрөнгө буюу хувьцаа эзэмшигчдийн өмчийн өөрчлөлт, үлдэгдэл, ажил гүйлгээнд анхаарлаа хандуулна уу. Хувьцаа эзэмшигчдийн өмчийн эцсийн өмчлөгчийн өөрчлөлт, ажил гүйлгээний нөлөөллөөс хамааран хувьцаат компанид үүсч болох эрсдлийн талаар дурдсан ба зарим онцлох тайлбарыг доор оруулсан болно. Бид энэхүү асуудлаар аудитын дүгнэлтээ өөрчлөөгүй болно.

2021 оны 02 дугаар сарын 09-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн багцын арилжаагаар “Ард Менежмент ҮЦК” ХХК нь “Е-Моние” ХК (хуучин нэр)-ийн 52,925 ширхэг хувьцааг худалдан авч тус компанийн нийт энгийн хувьцааны 90.4 хувийн эзэмшигч болсон.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр “Е-Моние” ХК-ийн шинэ Хувьцаа эзэмшигчдийн хурлын 21/04 тоот тогтоолоор компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлан компанийн оноосон нэрийг “Тэнгэрлиг медиа групп” ХК болгон өөрчилж 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн ба 5,941,457 ширхэг энгийн хувьцааг СЗХ-ны даргын 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 343 тоот тогтоолоор нэмж гарган нийт энгийн хувьцааны тоог 6,000,000 ширхэгт хүргэсэн. Нэмж гаргасан энгийн хувьцааг 4 нэр бүхий стратегийн хөрөнгө оруулагчдад хаалттай хүрээнд санал болгож эзэмшүүлсэн. Эдгээр хөрөнгө оруулагч нар нь өөрсдийн эзэмшлийн хувьцааг гэрээний 5 нэр бүхий компанийн энгийн хувьцаагаар солилцсоны үр дүнд “Тэнгэрлиг медиа групп” ХК нь “Про медиа нетворк” ХХК болон “Анрид” ХХК гэсэн охин компаниудыг эзэмшдэг толгой компани болсоныг аудитын явцад танилцсан.

Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд анхаарал хандуулахуйц аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Тусдаа санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон гүйцэтгэх удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь НББОУС 27, Тусдаа санхүүгийн тайлан (НББОУС 27)-ын дагуу санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ. Компанийн гүйцэтгэх удирдлага нь санхүүгийн тусдаа тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Тусдаа санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол тусдаа санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол тусдаа санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- ✓ Тусдаа санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- ✓ Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- ✓ Тусдаа санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид гүйцэтгэх удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид гүйцэтгэх удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Гүйцэтгэх удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайланг хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол улсын Компанийн тухай хуулийн 95.1-р зүйлд заасан хуулийн этгээд болох “Тэнгэрлиг медиа групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



БЭЙКЕР ТИЛЛИ
ДАЛАЙВАН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2022 ОНЫ 02 ДУГААР
САРЫН 28-НЫ ӨДӨР

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31-ний өдөр

(мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | 2021.12.31 | 2020.12.31 |
|--|---|-------------------------|
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Мөнгөн орлогын дүн /+/ Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | - | - |
| Мөнгөн зарлагын дүн /-/ Ажиллагсдад төлсөн Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн Татварын байгууллагад төлсөн Бусад мөнгөн зарлага | (236,098.1) (110,195.0) (23,401.2) (5,587.8) (96,914.1) | - - - - - |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (236,098.1) | - |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Мөнгөн орлогын дүн /+/ Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 3,032,178.5 3,032,178.5 | - - |
| Мөнгөн зарлагын дүн /-/ Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | (2,852,879.9) (2,879.9) (50,000.0) (2,800,000.0) | - - - - |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 179,298.6 | - |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Мөнгөн орлогын дүн /+/ Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан Мөнгөн зарлагын дүн /-/ Зээл, урьдчилгаанд төлсөн мөнгө Төрөл бүрийн хандив | 1,464,700.0 1,464,700.0 (188,616.3) (187,616.3) (1,000.0) | - - - - - |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | 1,276,083.7 | - |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 1,219,284.2 | - |
| Валютын ханшийн зөрүү Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.1 1,926.3 1,221,210.6 | - 1,926.3 1,926.3 |



Баталсан:

Г. Бат-Эрдэнэ

Гүйцэтгэх захирал

Д. Бат-Оюун
Санхүү эрхэлсэн захирал

А.Удвал

Нягтлан бодогч

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

Хавсаргасан тайлбар тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31-ний өдөр

(мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Тодруулга | 2021.12.31. | 2020.12.31. |
|--|-----------|----------------------|-------------|
| Борлуулалтын орлого | | - | - |
| Борлуулалтын өртөг | | | |
| Нийт ашиг | | - | - |
| Борлуулалт, маркетингийн зардал | 6.16 | (7,024.0) | |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 6.16 | (1,099,782.5) | |
| Үйл ажиллагааны ашиг (алдагдал) | | (1,106,806.5) | - |
| Үйл ажиллагааны бус орлого (зардал) | 6.15 | 906,437.0 | |
| Санхүүгийн ашиг, (алдагдал) цэвэр | 6.14 | 660,406.8 | |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | | 460,037.3 | |
| Орлогын татварын зардал | 6.17 | (46,165.9) | |
| Татварын дараах ашиг (алдагдал) | | 413,871.4 | - |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 6.18 | 11,171,520.0 | - |
| Нийт дэлгэрэнгүй орлого | | 11,585,391.4 | - |
| Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /төгрөг/ | | 268.07 | - |

Баталсан:



Д. Бат-Оюун
Санхүү эрхэлсэн захирал

А.Удвал
Нягтлан бодогч

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

Хавсаргасан тайлбар тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31-ний өдөр


| Үзүүлэлт | Хувьцааг капитал | Нэмж төлөгдсөн капитал | Өмчийн эздийн бусад хэсэг | (мянган төгрөгөөр) | |
|---|---------------------|------------------------------|---------------------------------|----------------------------------|---------------------|
| | | | | Хуримтлагдсан ашиг (алдагдал) | Нийт |
| 2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 5,000.0 | | | (3,573.7) | 1,426.3 |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга | | | | | |
| Залруулсан үлдэгдэл | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | |
| Зарласан ногдол ашиг | | | | | |
| 2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 5,000.0 | | | (3,573.7) | 1,426.3 |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга | | | | | |
| Залруулсан үлдэгдэл | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 594,145.7 | 12,352,289.1 | | 413,871.4 | 413,871.4 |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | 12,946,434.8 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | 11,171,520.0 | | 11,171,520.0 |
| 2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 599,145.7 | 12,352,289.1 | 11,171,520.0 | 410,297.7 | 24,533,252.5 |

Баталсан:



Г. Бат-Эрдэнэ

Гүйцэтгэх захирал



Д. Бат-Оюун

Санхүү эрхэлсэн захирал



А. Удвал

Нягтлан бодогч

Хавсаргасан тайлбар тодруулга нь энэхүү тайлангийн салಿಸгүй хэсэг болно.

"BAKER TILLY DALAWAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31-ний өдөр

(мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Тодруулга | 2021.12.31. | 2020.12.31. |
|---|-----------|---------------------|----------------|
| <u>ХӨРӨНГӨ</u> | | | |
| <u>Эргэлтийн хөрөнгө</u> | | | |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 6.1 | 1,221,210.6 | 1,926.3 |
| Худалдааны ба худалдааны бус авлага | 6.2 | 1,363,103.5 | |
| Зээлийн хүүний авлага | 6.3 | 12,817.8 | |
| Урьдчилж төлсөн зардал | 6.9 | 47,105.6 | |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | | 2,644,237.5 | 1,926.3 |
| <u>Эргэлтийн бус хөрөнгө</u> | | | |
| Үндсэн хөрөнгө (цэвэр) | 6.10 | 2,543.6 | 5,000.0 |
| Бусад олгосон зээл | 6.3 | 700,000.0 | |
| Хөрөнгө оруулалт | 6.4 | 13,131,084.8 | |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | 6.5 | 13,285,440.0 | |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | | 27,119,068.4 | 5,000.0 |
| НИЙТ ХӨРӨНГӨ | | 29,763,305.9 | 6,926.3 |
| <u>ӨР ТӨЛБӨР</u> | | | |
| <u>Богино хугацаат өр төлбөр</u> | | | |
| Худалдааны ба худалдааны бус өглөг | 6.6 | 107,293.0 | 5,500.0 |
| Татвар, шимтгэлийн өр | 6.11 | 140,386.6 | |
| Богино хугацаат зээл | 6.7 | 363,331.6 | |
| Зээлийн хүүний өглөг | 6.7 | 8,913.7 | |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | | 619,924.9 | 5,500.0 |
| <u>Урт хугацаат өр төлбөр</u> | | | |
| Урт хугацаат зээл | 6.7 | 1,066,668.4 | |
| Бусад урт хугацаат өглөг | 6.8 | 2,302,180.1 | |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 6.12 | 1,241,280.0 | |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | | 4,610,128.5 | |
| Нийт өр төлбөр | | 5,230,053.4 | 5,500.0 |
| <u>Өөрийн хөрөнгө</u> | | | |
| Хувийн өмч – Энгийн хувьцаа | 6.13 | 599,145.7 | 5,000.0 |
| Нэмж төлөгдсөн капитал | 6.13 | 12,352,289.1 | |
| Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг | 6.13 | 11,171,520.0 | |
| Хуримтлагдсан ашиг | 6.13 | 410,297.7 | (3,573.7) |
| Нийт өөрийн хөрөнгө | | 24,533,252.5 | 1,426.3 |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | 29,763,305.9 | 6,926.3 |

Баталсан:



Г. Бат-Эрдэнэ

Гүйцэтгэх захирал

Д. Бат-Оюун

Санхүү эрхэлсэн захирал

А.Удвал

Нягтлан бодогч

Хавсаргасан тайлбар тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно.

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LL
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL